



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 06 өдөр

Дугаар А/371

Чингис хот

Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын
ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын “а, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5, 6.6, 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9, 11 дүгээр зүйлийн 11.1.1.дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны 225 дугаар тогтоол, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2021 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн А/179 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүнс хөдөө аж ахуйн сайдын 2015 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/154 дүгээр тушаалаар батлагдсан “Малын бруцеллэзтой тэмцэх стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн А/56 тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор 2021 онд шинээр гарсан охин тугал, хурга, ишгийг бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2021 оны 8 дугаар сарын 01-ний өдрөөс 9 дүгээр сарын 01-нийг хүртэлх хугацаанд зохион байгуулахыг сумдын Засаг дарга, Мал эмнэлгийн тасгийн дарга нарт үүрэг болгосугай.

2. Дархлаажуулалтын ажлын хэсэгт Мал эмнэлгийн тасгийн мэргэжилтэн, багийн Засаг дарга нарыг томилон ажиллуулж, технологит хугацаанд нь үр дүнтэй зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд шаардлагатай вакцин, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангах, ажлын явц, чанар, гүйцэтгэлд хяналт тавих, үр дүнг танилцуулах ажлыг Мал эмнэлгийн газар (Н.Анхбаяр)-т, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Чогсомжав)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

• 231011863